



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ, ХОГ ХАЯГДЛЫН ДАХИН БОЛОВСРУУЛАЛТ, АШИГЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛТОТ ҮР ДҮНД ХҮРЭЭГҮЙ БАЙНА

**АУДИТЫН СЭДЭВ: “МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ХОГ ХАЯГДЛЫН ТАЛААР
БАРИМТАЛЖ БУЙ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ”**

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/23-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

**Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор Д.Энхболд**

Утас: 263755, цахим хаяг: enkhboldd@audit.gov.mn

Аудитын менежер Ю.Энхтуяа

Утас: 261456, цахим хаяг: enkhtuyayu@audit.gov.mn

Ахлах аудитор У.Оюунхүү

Утас: 261456, цахим хаяг: oyunkhuu@audit.gov.mn

Аудитор Ж.Оюунтуяа

Утас: 261456, цахим хаяг: oyuntuyaj@audit.gov.mn

Аудитор М.Доржмаа

Утас: 261456, цахим хаяг: dorjmaam@audit.gov.mn

Аудитор Б.Эрдэнэбаатар

Утас: 261456, цахим хаяг: erdenebaatarb@audit.gov.mn

Аудитор Д.Нямжаргал

Утас: 261456, цахим хаяг: Nyamjargald@audit.gov.mn

Аудитор Б.Идэрбалжинням

Утас: 261456, цахим хаяг: iderbaljinnyamb@audit.gov.mn

Аудитор Б.Уранчимэг

Утас: 261456, цахим хаяг: uranchimegb@audit.gov.mn

БҮЛЭГ 1. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭГ ДУНД, БОГИНО ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨЛТӨД ТУСГААГҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ҮР ДҮНГ ХЭМЖИГДЭХҮЙЦ БАЙДЛААР ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА

1.1. Байгаль орчны салбарын багц хуулиудын шинэчлэлийн хүрээнд Хог хаягдлын тухай хуулийг шинэчлэн баталснаар 2012 оны 5 дугаар сараас мөрдөж эхэлсэн ба уг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтыг үндэслэн Засгийн газрын 2014 оны 298 дугаар тогтоолоор “Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг баталжээ.

1.2. Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Мянганы хөгжлийн зорилтот суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого болон Ногоон хөгжлийн урт хугацааны бодлоготой уялдуулан төлөвлөсөн байна.

1.3. Харин хөтөлбөрийн үндсэн 5 зорилт, 22 үйл ажиллагаа, тэдгээрийг хэрэгжүүлэх 85 арга хэмжээнээс зарим арга хэмжээг дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг болох Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаагүй байна.

1.4. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 85 арга хэмжээнээс байгаль орчны салбарын яам хариуцан гүйцэтгэх 9, бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх 29, нийт 38 арга хэмжээг төлөвлөсөн боловч тус яамны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 20 арга хэмжээ буюу 52.6 хувийг нь тусгаагүй, төлөвлөлт уялдаагүй байна.

1.5. Салбарын яамны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй дээрх арга хэмжээний дийлэнх нь бусад яамд, Засаг дарга нартай хамтран хэрэгжүүлэх ажлууд бөгөөд хөтөлбөрийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж хэрэгжүүлэх зохион байгуулалт дутмаг, оролцогч талуудын хамтын ажиллагааг нэгдмэл байдлаар төлөвлөх үйл ажиллагаа хангалтгүй байгааг харуулж байна.

1.6. Энэ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д заасан хөгжлийн бодлого төлөвлөлтөд баримтлах “нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх” зарчимд нийцэхгүй байна.

1.7. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээнүүдийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөө, улсын төсөвт тусгахгүй орхигдуулж төлөвлөлтийг уялдуулаагүй нь хамтран хийж гүйцэтгэх арга хэмжээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн байна.

Үндэсний хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагаа бүрээр хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг тооцож төлөвлөөгүй, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 40 хувийн хүрэх үр дүнг хэмжигдэхүйц байдлаар тодорхойлоогүй байна

1.8. Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийг үнэлэх шалгууруудыг тодорхойлохдоо хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэлийг үнэлэх 5, төлөвлөгөө боловсруулах 1, олон улсын стандарт нэвтрүүлэх 1 нийт 7 шалгууртай харьцуулж дүгнэхээр тусгажээ.

1.9. Үндэсний хөтөлбөрийн үндсэн 5 зорилтод тусгасан агуулгыг хөтөлбөрийн шалгуур үзүүлэлттэй харьцуулан уялдааг хянахад хог хаягдлын эрх зүйн орчин, менежментийг боловсронгуй болгож хэрэгжилтийг сайжруулах, хариуцлага, урамшууллын тогтолцоог бүрдүүлэх нэгдүгээр зорилтын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг тодорхой төлөвлөөгүй байна.

1.10. Мөн “үйлдвэрлэлийн хог хаягдлын зохистой менежмент, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хүн амд ногоон хэрэглээний соёл, хог хаягдлыг ангилан ялгах, амьдрах орчны

эрүүл ахуйн зөв дадлыг төлөвшүүлэх замаар амьдралын тав тухтай орчин бүрдүүлэх” зорилтын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтгүй ба 5 зорилт, 22 үйл ажиллагаа бүрээр шалгуур үзүүлэлт, суурь болон хүрэх түвшнийг тодорхойлоогүй байна.

1.11. Үндэсний хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны биелэлтийг хангах зорилгоор нийт 85 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч 40 хувь буюу 34 арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг хэмжигдэхүйц байдлаар тодорхойлоогүйгээс үр дүнг нарийвчлан үнэлэх, хянах боломжгүй байдалд хүрсэн байна.

1.12. Энэ нь Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын 40¹ дэх заалтад нийцээгүй ба хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтийг шалгуур үзүүлэлтээр хянаж үнэлэх, үр дүнг сайжруулах боломжийг хязгаарлажээ.

1.13. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдсанаас хойш бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад баримтлах зарчим, тавигдах шаардлага зэргийг шинэчлэн баталсан боловч тус төлөвлөгөөг шинэчлэх, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлох, сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.

Үндэсний хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн зарим арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг тооцож төлөвлөөгүй, нэгдсэн бодлого, төлөвлөлт дутмаг байна

1.14. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд 85 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаснаас зөвхөн 32 арга хэмжээнд зарцуулах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөж нийт 329,085.0 сая төгрөг зарцуулахаар тусгасан бол 12 арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг тооцож тодорхойлоогүй, төлөвлөгөөнд тусгаагүй байна.

1.15. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд зарим арга хэмжээний зардлыг тооцож тусгаагүй нь улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламж, концессоор хэрэгжүүлэх арга хэмжээний жилийн төлөвлөгөөнд тусгагдахгүй орхигдох эрсдэлийг дагуулж байна.

1.16. Тухайлбал 2016-2022 онд хаягдлаар шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг үйлдвэрийг бүсийн төвүүдэд байгуулахыг дэмжих арга хэмжээг улсын төсөв, гадаадын зээл, тусламжаар, бүх аймаг, сумдын эмнэлгийн аюултай хог хаягдлыг халдваргүйжүүлэх, саармагжуулан түр хадгалах, устгах зориулалтын байгууламжтай болгох арга хэмжээг улсын төсвөөр тус тус хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч жилийн төсвийн төсөлд тусгаагүй байна.

1.17. Салбарын яам орон нутгийн удирдлагатай хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааг болон түүнд шаардагдах төсөв, санхүүжилтийг төсвийн төсөл боловсруулж батлуулах хугацаатай уялдуулж хэрэгжүүлэхгүй байгаа нь төсөв санхүү болон хийж гүйцэтгэх ажлыг харилцан уялдаатай төлөвлөж хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байгаа бөгөөд нэгдсэн бодлого, төлөвлөлт, зохион байгуулалт хангалтгүй байна.

¹ 40. “Тодорхой бодлогын баримт бичгийг боловсруулан батлахдаа зорилт бүрийн суурь болон шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүнг тодорхой тусгаж батална”

БҮЛЭГ 2. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ, ХОГ ХАЯГДЛЫН ДАХИН БОЛОВСРУУЛАЛТ, АШИГЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛТОТ ҮР ДҮНД ХҮРЭЭГҮЙ БАЙНА

2.1. Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд 5 зорилт, 22 үйл ажиллагааг 2014-2017 он, 2018-2022 он гэсэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгасан ба үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хөтөлбөр батлагдсанаас хойш нэг жилийн дараа буюу БОАЖС-ын 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/435 дугаар тушаалаар баталж 85 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

2.2. Төлөвлөсөн арга хэмжээ бүрийг хариуцан болон хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудаас хэрэгжилтийг гаргуулан үнэлэхэд нийт 85 арга хэмжээнээс 28.2 хувь буюу 24 арга хэмжээг хэрэгжүүлсэн, 40.0 хувь буюу 34 арга хэмжээ хэрэгжилт дутуу, 31.8 хувь буюу 27 арга хэмжээ нь хэрэгжүүлээгүй, үр дүн хангалтгүй байна.

2.3. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй, хөтөлбөрөөр төлөвлөсөн зорилт, үр дүнд хүрээгүй нь хэрэгжүүлэгч байгууллагуудын хамтын ажиллагаа, нэгдсэн удирдлага, зохион байгуулалт дутмаг, орон нутгийн түвшинд төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт хангалтгүйтэй холбоотой байна.

2.4. Хэрэгжилт дутуу болон хэрэгжээгүй 61 арга хэмжээний 59 хувь буюу 36 арга хэмжээг яам, агентлаг, орон нутгийн Засаг дарга нар хамтран хэрэгжүүлэх, 13 арга хэмжээг аймаг, нийслэлийн Засаг дарга, 5 арга хэмжээг салбарын яам, 7 арга хэмжээг бусад яамд дангаар хариуцан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлууд байна.

2.5. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг БОАЖЯ-аас нэгдсэн бодлогоор төлөвлөж хэрэгжүүлээгүй, бусад яамд болон орон нутгийн удирдлагатай хамтарч ажиллан хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.

Үндэсний хөтөлбөрийн зорилт 1. Хог хаягдлын эрх зүйн орчин, менежментийг боловсронгуй болгож хэрэгжилтийг сайжруулах, хариуцлага, урамшууллын тогтолцоог бүрдүүлэх

2.6. Тухайн зорилтын хүрээнд нийт 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 20 арга хэмжээний хэрэгжилт 44.5 хувь, 6 арга хэмжээг огт хэрэгжүүлээгүй байна.

2.7. Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд 2017 онд Хог хаягдлын тухай хуулийг шинэчлэн баталж, хог хаягдлын менежментэд оролцогч талуудын эрх үүрэг, энгийн, аюултай хог хаягдалтай холбогдох үйл ажиллагааг эрхлэх, зөвшөөрөл олгох, урамшуулах, үйлдвэрлэгч, импортлогч нь бараа, бүтээгдэхүүний хэрэглээнээс үүсэх хаягдал, сав баглаа боодлыг хариуцах, хог хаягдлын боловсрол олгох талаар тусгажээ.

2.8. Хуульд хог хаягдал дахин боловсруулах үйл ажиллагааг эрхэлсэн иргэн, аж ахуй нэгжийг урамшуулах, үйлдвэрлэгч болон импортлогч үйлдвэрлэсэн, импортолсон зарим бараа бүтээгдэхүүний хэрэглээнээс үүсэх хаягдал, сав баглаа боодлыг эргүүлэн татаж цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах асуудлыг хариуцахаар тусгасан боловч арга зам нь тодорхойгүйгээс хэрэгжилт хангалтгүй байна.

2.9. Дахин боловсруулах боломжтой хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэсэн ангилан ялгахыг дэмжих урамшууллын хөшүүрэг хэрэгжихгүй, үүсгэгч, бохирдуулагч төлөх татвар, төлбөрийн хариуцлага, дахин боловсруулах үйлдвэрүүдийг дэмжих, урамшуулах, хөнгөлөлт үзүүлэх арга зам тодорхойгүй, зохицуулалт хангалтгүй байна.

2.10. Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаас хог хаягдлын менежментийг сайжруулах хүрээнд дараах асуудлуудыг судалж танилцуулахыг Сангийн сайд болон БОАЖС-д үүрэг болгосон боловч хэрэгжүүлээгүй, БОАЖС-ын тушаалаар ажлын хэсэг байгуулагдан судалгаа хийж, саналын төсөл боловсруулснаа Засгийн газарт хүргүүлээгүй, хуралдаанаар хэлэлцүүлээгүй байна

2.11. Хог хаягдлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4²-д хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах, ашиглах, экспортлох зэрэг үйл ажиллагаа эрхлэгч иргэн, ААНБ-ыг дэмжиж урамшуулахаар, мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5³, 40 дүгээр зүйлийн 40.9⁴-д тухайн урамшууллыг олгох журам, хэмжээг аймаг, нийслэлийн ИТХ баталж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан боловч орон нутгийн төсвөөс урамшуулал олгосон тохиолдол байхгүй нь хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах, ашиглах, экспортлох үйл ажиллагааг дэмжих, урамшуулах хөшүүрэг хэрэгжихгүй байгааг харуулж байна.

2.12. Хог хаягдалтай холбоотой статистик мэдээллийг аймаг, сум бүрээр гаргуулан нэгтгэж байгаа боловч тухайн статистик мэдээнд хог хаягдлын нийт хэмжээг харилцан адилгүй тайлагнасан, үнэн бодит эсэх нь тодорхойгүй, хог хаягдлын бүтэц, төрөл, эх үүсвэрийн тоон мэдээллийн чанар хангалтгүй, цаас, шил, металл, хуванцар, барилгын, хүнс, биомассын, цахилгаан барааны хаягдал, хаягдал дугуй, бусад хаягдал гэсэн маягтад заасан ангилал бүрээр бүртгээгүй, тайлагнаагүй байна.

2.13. Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн хогийн цэгээс бусад хогийн цэгүүдэд жинлэх төхөөрөмж байхгүйгээс хог тээврийн машины ачилтын тоо, даацын мэдээлэлд тулгуурлан хог хаягдлын нийт тоог ойролцоогоор тооцоолж бүртгэж тайлагнадаг, хог хаягдлын бүтцийн судалгаа улсын хэмжээнд аймаг, сум бүрээр хийгдээгүй тул ангилал, төрөл бүрээр нарийвчилсан тоон мэдээлэлгүй байна.

2.14. БОНХАЖЯ, бүх шатны ЗДТГ хамтран 2016 онд дахин ашиглаж болох хог хаягдлын нарийвчилсан судалгаа хийх, 2017 онд улсын хэмжээнд хог хаягдлын нэгдсэн тооллого, бүртгэлийн ажлыг улсын төсвийн хөрөнгөөр зохион байгуулахаар төлөвлөсөн боловч хэрэгжүүлээгүй, 2019 онд зөвхөн Улаанбаатар хотын ахуйн хог хаягдлын бүтцийн судалгааг Азийн сангаас БОАЖЯ, Улаанбаатар хотын ЗАА-тай хамтран хийсэн бөгөөд тухайн бүтцийн судалгааг Үндэсний статистикийн хороо статистик мэдээндээ ашиглаж байна.

2.15. Үүнээс шалтгаалан улсын хэмжээний тооллого бүртгэл хийх, мэдээллийн цахим сан бүрдүүлж, хог хаягдлын хэмжээ урсгалыг байнга хянах зорилтот үр дүнд хүрээгүй, хог хаягдлын хэмжээ, бүтцийн тоон мэдээллийг бодитоор бүртгэж тайлагнаж, хянаж чадахгүй байна.

Үндэсний хөтөлбөрийн зорилт 2. Үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, нөөц, түүхий эдийн зарцуулалтыг багасгах, хэмнэх замаар хог хаягдлыг бууруулах болон хаягдалгүй дэвшилтэт технологийг дэмжих, үйлдвэрлэлийн хог хаягдлын зохистой менежмент, хяналтын тогтолцоог бүрдүүлэх

² 40.4."Энэ хуулийн 40.5-д заасан үйлдвэрлэгч болон импортлогчоос бусад дараах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эдийн засгийн урамшуулал олгоно: 40.4.1.хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах, экспортлох үйл ажиллагаа эрхлэгч; 40.4.2.байгаль орчинд ээлтэй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн; 40.4.3.цаас, лааз, шил, хуванцар зэрэг дахин боловсруулах боломжтой энгийн хог хаягдлыг ангилсан хог хаягдал худалдан авах цэгт хүлээлгэн өгсөн"

³ 9.1.5. "Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл энэ хуулийн 40.4, 40.9, 40.10-т заасан урамшууллыг олгох шалгуур үзүүлэлт, урамшууллын хэмжээ, түүнийг олгох, санхүүжүүлэх, зарцуулах журмыг батлах"

⁴ 40.9. "Энэ хуулийн 40.4-т заасан урамшуулал нь мөнгөн, эсхүл ногоон онооны хэлбэртэй байх бөгөөд орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ"

2.16. Дээрх зорилтын хүрээнд нийт 21 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 12 арга хэмжээг хэрэгжүүлээгүй, 9 арга хэмжээний хэрэгжилт 22.7 хувьтай байна.

2.17. Хог хаягдлын тээвэрлэлтийн 2022 оны мэдээгээр нийт хог хаягдлын 20 гаруй хувь нь аймгийн төвүүдэд үүсэж байгаа боловч дахин боловсруулах үйлдвэр байхгүй, хог хаягдлыг ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх асуудал хүндрэлтэй, тогтсон систем, нэгдсэн бодлого, зохицуулалтгүй байгаа нь боловсруулах боломжтой энгийн болон аюултай хог хаягдлыг дарж булах, шатаахад хүргэж байна.

2.18. Тухайлбал хуванцар дахин боловсруулах үйлдвэрийн тоо 2022 онд 21-т хүрч 2019 онтой харьцуулахад 3 дахин нэмэгдсэн боловч түүхий эд буюу хуванцар хог хаягдлын нийлүүлэлтийн систем тогтворгүйгээс шалтгаалан түүхий эдийн олдоц буурах, үнэ өсөх хүндрэлүүд үүсэж үйлдвэрийн хүчин чадлыг бүрэн ашиглаж чадахгүй байна.

Үндэсний хөтөлбөрийн зорилт 3. Аюултай хог хаягдлын менежментийг сайжруулж байгаль орчинд хал багатайгаар зайлуулах чадавхыг бүрдүүлж, хуримтлагдахаас сэргийлэх

2.19. Аюултай хог хаягдлын менежментийг сайжруулах дээрх зорилтын хүрээнд 8 арга хэмжээг төлөвлөснөөс 2018 онд аюултай хог хаягдлын жагсаалтыг баталж, судалгаа мэдээллийг нэгдсэн цахим санд төвлөрүүлэн бүртгэх, тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлохтой холбоотой эрх зүйн актуудыг шинэчлэх ажлыг хэрэгжүүлжээ.

2.20. Харин дараах 6 арга хэмжээний хэрэгжилт дутуу болон хэрэгжээгүйгээс аюултай хог хаягдлыг хор нөлөө багатай зайлуулах чадавхыг бүрдүүлэх, хуримтлагдахаас сэргийлэх зорилтод хүрээгүй байна.

2.21. Аюултай хог хаягдал нь үйлдвэрлэл, эрүүл мэндийн байгууллага, лаборатори, барилга, нураалт, лаг, хөдөө аж ахуй зэргээс үүсдэг бөгөөд 2021 онд аюултай хог хаягдлын хэмжээ улсын хэмжээнд 223.0 мянган тонн байсан бол 2022 онд 28.2 хувиар нэмэгдэж 285.9 мянга, 2023 онд 51.7 хувиар өсөж 433.9 мянган тоннд хүрчээ.

2.22. Аюултай хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй аргаар булшлах, устгах болон хоргүйжүүлэх зорилго бүхий төвлөрсөн, бүсчилсэн байгууламж байхгүй, дахин боловсруулах асуудал дутагдалтайгаас аюултай хог хаягдал их хэмжээгээр хуримтлагдах, зориулалтын бус газар хадгалах, зориулалт бусаар шатаах, энгийн хаягдалтай хамт хаях, булшлах зэргээр хүрээлэн буй орчинд хохирол үзүүлэх эрсдэлтэй байна.

2.23. Мөн аюултай хог хаягдал үүсгэх импортын бараа, бүтээгдэхүүн, химийн хорт, аюултай бодисыг гаалиар нэвтрүүлэхээс эхлэн худалдан борлуулах, үйлдвэрлэл, хэрэглээнд зарцуулах, хаягдал үүсэх, хадгалах, устгах хүртэлх үе шатыг хамруулсан бүртгэл, мэдээлэл, хяналтын нэгдсэн систем байхгүй, оролцогч талууд хоорондоо мэдээлэл солилцох боломж хязгаарлагдмал байгаа нь аюултай хог хаягдлыг хянахад хүндрэл учруулж байна.

2.24. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2020-2022 онд хэрэгжих техник туслалцааны хүрээнд химийн хортой болон аюултай бодис, химийн бодис агуулсан зарим бараа бүтээгдэхүүний нэгдсэн суурь бүртгэл хийх, хилээр нэвтэрч буй химийн бодисын шилжилт хөдөлгөөн, тээвэрлэх, ашиглах, хадгалах, устгах бүх процессыг бүртгэх цахим систем бүрдүүлэхээр төлөвлөсөн боловч бүрэн хэрэгжиж дуусаагүй байна.

2.25. Иймд аюултай хог хаягдлын менежментэд оролцогч, хяналт хэрэгжүүлэгч талуудыг бүрэн хамруулсан нэгдсэн мэдээллийн сан бүхий цахим системийг хөгжүүлж хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Үндэсний хөтөлбөрийн зорилт 4. Хүн амд ногоон хэрэглээний соёл, хог хаягдлыг ангилан ялгах, амьдрах орчны эрүүл ахуйн зөв дадлыг төлөвшүүлэх замаар амьдралын тав тухтай орчин бүрдүүлэх

2.26. Тухайн зорилтын хүрээнд нийт 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 14 арга хэмжээний хэрэгжилт 64.3 хувь, 4 арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:

Хэрэгжүүлээгүй арга хэмжээ:

- АҮЯ хариуцан 2016 онд “Стандартад нийцсэн хогийн сав, бусад багаж хэрэгслийг дотооддоо үйлдвэрлэх үйлдвэр байгуулахыг дэмжих”;
- Бүх шатны Засаг дарга нар хариуцан 2016 онд “Урьдчилан инженер геологийн судалгаа хийсний үндсэн дээр хог хаягдлын төвлөрсөн цэгийн байршлыг тогтоох, стандартын шаардлагад нийцүүлэн ТЭЗҮ боловсруулах”;
- Бүх шатны Засаг дарга нар хариуцан 2016-2022 онд “Нийслэл, аймгийн төвийн төвлөрсөн хогийн цэгт байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөө /БОМТ/-г хэрэгжүүлэх”;
- ЗТЯ, ТХГН-ын захиргаа хамтран 2015-2022 онд “Аялал жуулчлалаар явж байгаа иргэдэд ил задгай хог хаягдал хаяхгүй байх талаар мэдээлэл сурталчилгаа тогтмол хийж, хөдөө орон нутгийн зам дагуу хог хаяхыг хориглосон тэмдэгжүүлэлт хийх, хог хаягдлын цэгийг тодорхой зайтайгаар байгуулах” арга хэмжээг тус тус төлөвлөсөн боловч хэрэгжүүлээгүй байна.

2.27. Хог хаягдлыг бууруулах арга зам, ангилах, аюултай хог хаягдлыг ялгахтай холбоотой асуудлаар иргэдийн мэдлэг бага⁵, олон нийтэд таниулах, сурталчлах, мэдлэг боловсрол олгох үйл ажиллагаа тогтмол бус, нэгдсэн системгүй, нэг удаагийн арга хэмжээ, аян хэлбэрээр төлөвлөж, зохион байгуулсан нь хамрах хүрээ, үр нөлөө багатайгаас хүн амд зөв дадал төлөвшүүлэх зорилтоо хангаж чадаагүй байна.

2.28. Нөгөө талаас иргэд хог хаягдлаа ангилах нь зөв гэдэгтэй бүрэн санал нийлж, эерэг хандлага бүрэлдэж, ангилах, ялгах чиглэлд иргэн, төрийн бус байгууллагаас санал санаачилга гаргаж байгаа боловч ангилан ялгаж хаях хогийн савгүй, ангилан тээвэрлэх систем байхгүй нь идэвх санаачилгыг бууруулж байна.

2.29. Энэ нь нэгдсэн зохион байгуулалтаар хогийг эх үүсвэр дээр нь ангилж ялгах тогтолцоонд шилжихэд хүндрэл учруулж, ашиглах боломжтой хаягдлыг дахин боловсруулахгүй хаях шалтгаан болж байна.

Үндэсний хөтөлбөрийн зорилт 5. Хог хаягдлыг дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, эрчим хүч гаргах зэрэг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар байгальд булж зайлуулах хаягдлын хэмжээг бууруулах

2.30. Тухайн зорилтын хүрээнд 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжсэн 4, хэрэгжилт дутуу буюу 40.6 хувийн хэрэгжилттэй 4 арга хэмжээ байна. Үүнд:

Хэрэгжээгүй арга хэмжээ:

⁵ “Сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгаа” 2021 он, “SICA” ХХК, захиалагч “Каритас Чех Републик”

- БОНХАЖЯ, АҮЯ, БХБЯ хамтран “Хаягдлаар байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг үйлдвэрийг бүсийн төвүүдэд байгуулахыг дэмжих” арга хэмжээг улсын төсөв, гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч байгуулагдаагүй;
- Орхон аймгийн ЗДТГ хариуцан 2016-2017 онд “Жилд 25000 тонн холимог хог хаягдал боловсруулах хүчин чадалтай байгууламж байгуулах”;
- БХБЯ, НЗДТГ хамтран 2016-2022 онд “Хаягдлаар нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслийг концессын жагсаалтад оруулж хэрэгжүүлэх замаар өрсөлдөөнийг зохицуулж, татварын таатай нөхцөлөөр дэмжих”;
- БОНХАЖЯ хариуцан 2016-2017 онд “Импортлогчид олон дахин ашиглагдах бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, өөрсдийн нийлүүлж байгаа бараанаас гарах хог хаягдлын менежментийг шийдэх хариуцлага хүлээх чиглэлээр эрх зүйн зохицуулалт бий болгож хэрэгжүүлэх”-ээр тус тус төлөвлөсөн ч хэрэгжүүлээгүй байна.

Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөрөөр төлөвлөсөн зорилтот үр дүнд хүрээгүй байна

2.31. Салбарын яам нь үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах үүрэгтэй боловч хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнтэй холбоотой зарим нэгдсэн судалгаа, мэдээлэл байхгүй, тайланд тусгаагүй, тайлагнаагүй зэргээс хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх 7 шалгуур үзүүлэлтээс дараах 4 шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлээр хүрсэн түвшин тодорхойгүй, төлөвлөсөн зорилтот үр дүнд хүрсэн эсэхийг тодорхойлох боломжгүй байна.

2.32. Үндэсний хөтөлбөрийн хүрээнд байгальд булж зайлуулах хог хаягдлын хувь хэмжээг 2018 онд 90 хувь, 2022 онд 78 хувьд хүргэж бууруулахаар төлөвлөсөн ба Үндэсний статистикийн хорооны 2022 оны мэдээгээр нийт хог хаягдлын 72.2 хувийг ландфилд булж, 8.4 хувийг шатааж, 11.7 хувийг байгальд хаяж, экспорт болон бусад салбарын завсрын хэрэглээнд 7.6 хувийг зарцуулсан байх бөгөөд байгальд булж зайлуулах хаягдлын хувь хэмжээг 78 хувьд хүргэж бууруулах дээрх зорилт нь хэрэгжсэн байна.

2.33. Харин дахин боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх хог хаягдлын хэмжээг нэмэгдүүлж 2022 онд 22 хувьд хүргэхээр, эргүүлэн ашиглах сав, баглаа боодлын хэмжээг 2022 онд 135.0 мянган тоннд хүргэхээр тус тус төлөвлөсөн боловч зорилтот түвшинд хүрээгүй, хэрэгжээгүй байна.

2.34. Хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах асуудлыг хууль журмаар зохицуулсан боловч хэрэгжилт хангалтгүй, хэрэгжилтийг хянаж хариуцлага тооцох, урамшуулах тогтолцоо бүрдээгүй ба үнс, цаас, металл, шил болон бусад задрах, боловсруулах боломжтой хогийг эх үүсвэр дээр нь ангилж, ялгах шаардлагатай байна.

2.35. Суурьшлын бүс, нэгж бүрээр хог хаягдлын ангилал, нэр төрөл, эзлэх хувь, бүтцийн талаарх мэдээлэл байхгүй, ангилсан хуванцар хаягдал авах, цуглуулах цэг, байршил, сүлжээний талаар судалгаа, тооцоолол хийгээгүй байна.

2.36. Салбарын яамнаас хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байгаа боловч нэгдмэл, цогц байдлаар зохион байгуулж шийдвэрлэж чадахгүй байна.

Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, хөрөнгийн зарцуулалт үр дүнгүй байна

2.37. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь үндэсний хөтөлбөрийн хүрээнд улс, орон нутгийн төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын санхүүжилт, гадаадын зээл, тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр төлөвлөж, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний зарцуулалт, үр дүнгийн талаарх нэгтгэсэн судалгаа, тоон мэдээлэлгүй байна.

2.38. Аудитын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ-г 2015-2023 оны төсвийн тухай хуулиас, гадаадын зээлээр хэрэгжсэн ТАХ-ний мэдээллийг Сангийн яамны гадаадын зээл, тусламжийн удирдлагын систем /odamis.mof.gov.mn/-ээс судалгаа хийж нэгтгэхэд 74,360.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нийт 30 ТАХ-г санхүүжүүлжээ.

2.39. Дээрх 32 ТАХ-ээс 66,270.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 ТАХ-г түүвэрлэн аудит хийхэд төсөл, арга хэмжээний төлөвлөлт хангалтгүй, хэрэгжилт удааширч зогссон, захиалагчийн хяналт дутуу хэрэгжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.1⁶ дах заалтыг зөрчсөн тул дутуу хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах албан шаардлагыг БОУАӨЯ-нд хүргүүлэв.

2.40. Хог хаягдлыг бууруулах зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалт, урсгал зардал, гадаад зээлээр санхүүжүүлсэн хог хаягдлыг ангилан ялгах үйлдвэр, дунд оврын шатаах зуух, ахуйн болон цэвэрлэх байгууламжийн лагийг шатааж устгах үйлдвэр, аюултай хог хаягдлын агуулах барих 45,799.2 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, ашиглалтад ороогүйгээс төлөвлөсөн зорилтод хүрээгүй байна.

2.41. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Барилга, хот байгуулалтын сайдын багцад 2016 оноос 2022 онд хог хаягдлын чиглэлээр хэрэгжсэн 16,286.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 ТАХ-нд 12,948.7 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

2.42. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн систем /odamis.mof.gov.mn/-д хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр техникийн туслалцаа болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 2014 оноос эхлэн хэрэгжсэн 19 төслийн нэр, санхүүжүүлэгч байгууллага бүхий товч мэдээлэл бүртгэгдсэн боловч дээрх төслийн нэгжүүд нь төслийн санхүүжилт, зарцуулалт, хэрэгжилт, үр дүнгийн талаарх үр нөлөөний үнэлгээний тайланг системд байршуулаагүйгээс зарцуулалт, үр дүнг хянах боломжгүй байна.

2.43. БОУАӨЯ нь хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлд гадаадын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилт, зарцуулалт, үр дүнгийн талаар дэлгэрэнгүй, иж бүрэн судалгаа, мэдээлэл байхгүй, нэгтгэсэн дүн шинжилгээ хийгээгүй байгаа нь улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, урсгал зардал, гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх болон хэрэгжсэн ТАХ-ний санхүүжилтийн эх үүсвэрийг уялдуулах, хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг давхардуулахгүйгээр төлөвлөх, зарцуулалт, үр дүнг хянаж удирдах боломжийг хязгаарлаж байна.

⁶ 6.4.1. “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”

2.44. Улаанбаатар хот нийтийн аж ахуй, тохижилт үйлчилгээний зардалд 2016 онд 10,758.5 сая төгрөг зарцуулж байсан бол 2023 онд 31,628.5 сая төгрөгт хүрч 3 дахин өссөн бөгөөд үүнд нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээний зардал 8,069.8 сая төгрөгөөс 2.8 дахин өссөн нь голлон нөлөөлсөн ба энэ чиглэлүүдэд илүү үр дүнтэй технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлэх, орчин үеийн автоматжуулалт, үр ашигтай хуваарилалт ашиглах замаар зардлыг бууруулах боломжийг судлах шаардлагатай байна.

2.45. Төвлөрсөн хогийн цэгт хог хаягдлыг хөрсөөр дарж булах үйл ажиллагааны зардал тухайн жилүүдэд 4,062.7 сая төгрөг буюу 12.8 хувиар өссөн байх боловч хог ангилан ялгах чиглэлээр 2018 оноос хойш зардал гаргаагүй ба дарж булшлах хогийн хэмжээг бууруулах, түүнд зарцуулж буй зардлыг багасгахын тулд хог ангилан ялгах, дахин боловсруулах үйл ажиллагааны төсөв, хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангах механизмыг бүрдүүлэх шаардлагатай байна.

2.46. Хууль бусаар ил задгай хаясан үүсмэл болон хур хог хаягдлыг цэвэрлэх зардалд жил бүр Улаанбаатар хотын ЗАА-аас 200.0 сая, нийт 2016-2023 онд 1,600.0 сая төгрөгийг зарцуулсан байгаа нь Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хянах тогтолцоо бүрдээгүй, хог хаягдлыг зориулалтын бус газарт хаях зөрчлийг илрүүлэх, хариуцлага тооцох ажиллагаа бүрэн хэрэгжихгүй байгааг харуулж байна.

2.47. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогоор 2017-2021 онд жилд дунджаар 19,391.3 сая төгрөг төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс жилд дунджаар 29,333.5 сая төгрөгийг хог хаягдлыг тээвэрлэх, дарж булшлах үйл ажиллагаанд зарцуулжээ.

2.48. Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 дахь хэсгийн 23.8.12-т заасны дагуу хог хаягдлын үйлчилгээний хураамж нь сум, дүүргийн төсвийн татварын орлогод төвлөрч байгаа ч дээрх хог хаягдлын үйл ажиллагааны санхүүжилтээс үзэхэд хог хаягдлын үйлчилгээний хураамжаас орж байгаа татварын орлого бага, орон нутгийн төсвөөс гарч байгаа санхүүжилт 2 дахин их байгаа нь хог хаягдлын үйлчилгээний хураамж бодит өртөгт суурилан тогтоогдохгүй байгааг харуулж байна.

БҮЛЭГ 3. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ҮНДЭСЛЭН САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ АВААГҮЙ БАЙНА

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг шалгуур үзүүлэлт бүрээр үнэлээгүй, зорилтот үр дүнд хүрээгүй шалтгаан, үр дагаврыг тодорхойлоогүй, сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна

3.1. БОНХАЖЯ үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг 2015-2019 онд 5 зорилтын хүрээнд, 2020-2021 онд зорилтыг хэрэгжүүлэх 22 үйл ажиллагааны хүрээнд тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт жил бүр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн ба 2022 онд хэрэгжилтийг тайлагнаагүй, хяналт-шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.

3.2. Мөн БОНХАЖЯ-аас хүргүүлсэн хөтөлбөрийн хэрэгжилтэд ЗГХЭГ-аас 2017-2021 онд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, нэгдсэн дүнг Засгийн газарт танилцуулсан боловч 2015 он, 2016 он, 2022 онд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй, Засгийн газрын хуралдаанд танилцуулаагүй орхигдуулжээ.

3.3. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнахдаа үнэлгээний 7 шалгуур үзүүлэлт бүрийн тухайн онд хүрсэн түвшнийг тодорхойлж тайлагнаагүй, мөн үнэлгээ хийхдээ шалгуур үзүүлэлт бүрээр зорилтот түвшнийг хүрсэн түвшинтэй харьцуулж үнэлээгүй байна.

3.4. Үндэсний хөтөлбөр баталж хэрэгжүүлсний үр дүнд төлөвлөсөн бодлого, зорилтууддаа хүрсэн эсэх, гарсан ахиц дэвшил, тулгарч буй хүндрэл бэрхшээл, тэдгээрийг шийдвэрлэх арга зам, анхаарах асуудал, цаашид хууль журам, урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгах, өөрчлөх эсэх асуудлууд тодорхойгүй орхигджээ.

3.5. Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг 2015-2021 онд БОНХАЖЯ 50.0-97.2 хувиар, ЗГХЭГ 0-97.2 хувиар тус тус үнэлсэн боловч эдгээр үнэлгээний үндэслэл, тооцоолол нь тодорхойгүй, зарим арга хэмжээний хэрэгжилтийг бодитоор тайлагнаагүй, үнэлээгүй байна.

3.6. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг бодитоор тайлагнаагүй, төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг харьцуулан үнэлээгүйгээс шалтгаалан хэрэгжилт хангалтгүй байгаа зорилт, арга хэмжээний шалтгаан үр дагаврыг судалж, сайжруулах боломжийг алдсан байна.

Хог хаягдлын талаарх хууль тогтоомжийг боловсронгуй болгох, менежментийг сайжруулах санал, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий Хог хаягдлын мэргэжлийн зөвлөл нь чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна

3.7. Хог хаягдлын тухай хуулийг 2017 онд шинэчлэн батлахдаа БОНХАЖЯ-ны дэргэд орон тооны бус Хог хаягдлын мэргэжлийн зөвлөл ажиллахаар, зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг салбарын сайд батлахаар тус тус хуульчилж, дараах 2 чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгажээ. Үүнд:

- *Хог хаягдлын талаарх хууль тогтоомжийг боловсронгуй болгох, менежментийг сайжруулах санал, зөвлөмж гаргах;*
- *Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг аж ахуйн нэгж, байгууллагад олгохтой холбоотой дүгнэлт, зөвлөмж гаргах.*

3.8. Хог хаягдлын мэргэжлийн зөвлөл нь 2018-2024 онд нийт 19 удаа хуралдсан боловч хог хаягдлын талаарх хууль тогтоомжийг боловсронгуй болгох, менежментийг сайжруулах чиглэлээр асуудал хэлэлцээгүй, санал, зөвлөмж гаргаагүй буюу хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

3.9. Мэргэжлийн зөвлөл нь бүрэлдэхүүндээ байгаль орчин, уул уурхай, барилга хот байгуулалт, зам, тээвэр, эрчим хүч, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Цагдаагийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Байгаль орчны судалгаа, шинжилгээний төвийн болон төрийн бус байгууллага, судлаачдын төлөөллийг оролцуулсан боловч хог хаягдлын менежментийг сайжруулах, салбар дундын уялдааг хангах чиглэлээр арга хэмжээ авч ажиллаагүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Үндэсний хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагаа бүрийг үнэлэх шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг хэмжигдэхүйц байдлаар тодорхойлоогүй, шаардлагатай хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг зарим арга хэмжээнд нарийвчлан тооцоогүй, төлөвлөлт оновчгүй байна.
2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан зарим арга хэмжээг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө, яамдын жилийн төлөвлөгөө, төсөв зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгаагүй, төлөвлөлт харилцан уялдаагүй байна.
3. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 85 арга хэмжээ нь 47.5 хувийн хэрэгжилттэй, хариуцлага, урамшууллын тогтолцоог бүрдүүлэх, хог хаягдлыг бууруулах, аюултай хог хаягдал хуримтлагдахаас сэргийлэх, дахин боловсруулсан хог хаягдлын хэмжээ, хаягдлыг устгаж зайлуулах зориулалтын байгууламжийг нэмэгдүүлэх зорилтууд хэрэгжээгүй, үр дүн хангалтгүй байна.
4. Хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор улсын төсөв, гадаад зээлээр санхүүжүүлсэн ангилан ялгах үйлдвэр, дунд оврын шатаах зуух, ахуйн болон цэвэрлэх байгууламжийн лагийг шатааж устгах үйлдвэр, аюултай хог хаягдлын агуулах барих ажлууд бүрэн хэрэгжээгүй, ашиглалтад ороогүйгээс хөрөнгийн зарцуулалт үр дүнгүй болсон байна.
5. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг шалгуур үзүүлэлт бүрээр тодорхойлж тайлагнаагүй, төлөвлөсөн болон хүрсэн зорилт, үр дүнг харьцуулж бодитоор үнэлээгүй, зорилтот үр дүнд хүрээгүй шалтгаан, үр дагаврыг тодорхойлох, сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.
6. Аюултай хог хаягдал үүсгэх бараа, бүтээгдэхүүн, химийн хорт, аюултай бодисыг гаалиар нэвтрүүлэхээс худалдан борлуулах, зарцуулах, хаягдал үүсэх, хадгалах, устгах хүртэлх үе шатыг хамруулсан бүртгэл, мэдээлэл, хяналтын нэгдсэн систем байхгүй, хянах тогтолцоо бүрдээгүй байна.
7. Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх нэгдсэн бодлого, зохион байгуулалт дутмаг, санхүүжилтийн тогтвортой механизм, хэрэгжүүлэх дэд бүтэц, эх үүсвэр дээр нь ангилан ялгах, дахин боловсруулах, бууруулах үйл ажиллагааг дэмжих урамшуулах хөшүүрэг, хаягдлыг үүсгэгч, бохирдуулагч нь хариуцах, төлөх татвар, төлбөрийн систем бүрдээгүй байна.
8. Үндэсний хөтөлбөр хэрэгжиж дуусахад хөтөлбөрийн явцын болон эцсийн үнэлгээ, үр нөлөөг үнэлж дүгнээгүйгээс гарсан ахиц дэвшил, тулгарч буй хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг тодорхойлоогүй, төлөвлөсөн бодлого, зорилтууддаа хүрсэн эсэх цаашид анхаарах асуудал, хууль журам, бодлогын баримт бичгүүдэд өөрчлөлт оруулах, сайжруулах шаардлагатай эсэх нь тодорхойгүй орхигджээ.
9. Салбар бүрийн төлөөллөөс бүрдсэн Хог хаягдлын мэргэжлийн зөвлөл нь хог хаягдлын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, менежментийг сайжруулах санал, зөвлөмж гаргах хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүй, хууль, журам, стандартыг шинэчлэх, батлан мөрдүүлэх, салбар хоорондын уялдааг хангах асуудал орхигдсон байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД-д:

1. Хог хаягдлын тухай хуульд заасан үйлдвэрлэгч, импортлогчийн хариуцлага, дахин ашиглах, боловсруулахыг урамшуулах зохицуулалтад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж шинэчлэн сайжруулах санал боловсруулан УИХ-д хүргүүлэх, хэлэлцүүлэх;
2. Хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулах, экспортлох үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг дэмжих, урамшуулах, хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах чиглэлээр хуульд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР-т:

1. Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, менежментийг сайжруулах чиглэлээр санал боловсруулж холбогдох хууль журам, бодлогын баримт бичгүүдэд тусгах, өөрчлөх шаардлагатай асуудлуудыг шийдвэрлүүлэх, салбар хоорондын уялдаа, хамтын ажиллагааг хангаж ажиллах;
2. Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэлд тусгасан хог хаягдлын менежменттэй холбоотой асуудлаар өгсөн үүрэг чиглэлийн хэрэгжилтийг хангуулж, үр дүнг үнэлэх.

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД-д:

1. Олон талын оролцоог хангасан ажлын хэсэг байгуулан хог хаягдлын менежментийг сайжруулахад тэргүүлэх ач холбогдолтой зорилт, арга хэмжээнүүдийг тодорхойлж, хэрэгжүүлэх үе шат бүрийг оновчтой тооцоолон хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, хариуцах байгууллага, хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөж Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгуулахаар Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлэх;
2. Хог хаягдлын тухай хуульд заасан үйлдвэрлэгч, импортлогчийн хариуцлага, урамшууллын зохицуулалтад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж шинэчлэн сайжруулах санал боловсруулж Засгийн газарт хүргүүлэх;
3. Аюултай хог хаягдлын менежментэд оролцогч, хяналт хэрэгжүүлэгч талуудыг бүрэн хамруулсан, үйлдвэрлэх, импортлох, үүсэхээс эхлэн хэрэглэх, устгах хүртэлх дата мэдээллийг агуулсан нэгдсэн цахим сан, систем бүрдүүлж хяналтыг сайжруулах;
4. Хог хаягдлын менежментийг бүх шатанд цогцоор зохицуулах хууль эрх зүйн шинэчлэл хийх, төлбөр, хураамжийн зарцуулалт, үр ашгийг тооцоолж урамшуулал, хариуцлагын тогтолцоог бий болгох чиглэлээр санал боловсруулж Засгийн газарт хүргүүлэх;
5. Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, урсгал зардал, гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний нэгдсэн судалгааг бүрдүүлж, хэрэгжилт, үр дүнд хоёр жил тутамд дотоод аудит хийх;
6. Урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан хог хаягдлын менежментийг сайжруулах зорилт, арга хэмжээг жил бүрийн төлөвлөгөөндөө

тусгаж уялдуулан шалгуур үзүүлэлт бүрээр хэрэгжилт, үр дүнг харьцуулан тайлагнах, үнэлэх;

7. Хог хаягдлын нэгдсэн стандарт, зохицуулалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах, батлуулах, олон улсын туршлагыг нутагшуулах, хогийн сав, баглаа боодлын материалд нэгдсэн стандарт тогтоож мөрдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
8. Хог хаягдлын мэргэжлийн зөвлөлийн дүрмийг хуульд нийцүүлэн шинэчлэн батлах;
9. Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хянах үйл ажиллагаанд “Хаягдлын олон нийтийн байцаагчийн хяналт, удирдлага, мэдээллийн нэгдсэн систем”-ийг ашиглах;
10. Хог хаягдалтай холбоотой статистик мэдээлэлд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж найдвартай эх үүсвэрээс, бодитой мэдээлэл цуглуулах, нэгдсэн бодлого, зарчмаар бүртгэж тайлагнахад чиглүүлэн сайжруулж статистик мэдээлэл боловсруулах, тайлагнах заавар боловсруулж батлуулах